



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/234

Арвайхээр

Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг  
зохион байгуулж явуулах тухай

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.10, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/50 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын нэрэмжит, аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгуулж явуулсугай.

2.Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, тэмцээнийг шүүх шүүгчдийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, шаардагдах зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулж явуулахад шаардагдах 3,069,100 (гурван сая жаран есөн мянга нэг зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

4.Тэмцээний бэлтгэл болон зохион байгуулах үеийн арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (хурандаа М.Дэлгэрсайхан)-д, батлагдсан удирдамж, заавар, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, хөдөлгөөний үеийн аюулгүй ажиллагааны болон бусад холбогдох дүрэм, журмыг сайтар мөрдүүлж ажиллахыг сумдын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

5.Тэмцээнийг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, дүнг илтгэхийг Цэргийн штабын дарга, ажлын хэсгийн ахлагч (хурандаа М.Дэлгэрсайхан)-д даалгасугай.

ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0505

Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 09-ны өдрийн  
..... дугаар захирамжийн  
..... дүгээр хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ, АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ,  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: М.Дэлгэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб дарга, хурандаа)

Гишүүд: Н.Гүрбадам (Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч, дэд хурандаа)

Б.Галбат (Зэвсэгт хүчний 113 дугаар тусгай салбарын захирагч хошууч)

Д.Одонбаяр (аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)

Б.Мөнх-эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Н.Чимэддорж-Ойдов (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Өсөх-эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Т.Баттүшиг (аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Э.Хүдэрчулуун (аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн дарга)

Ж.Энх-Амар (аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)

Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 09-ны өдрийн  
0134 дугаар захирамжийн  
08 дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ, АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙГ ШҮҮХ  
ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ерөнхий шүүгч:

М.Дэлгэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Цэргийн штабын дарга, хурандаа)

Ерөнхий шүүгчийн туслах, цагийн шүүгч:

Х.Чинзориг (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол,  
шинжлэх ухааны газрын Биеийн тамирын боловсрол  
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ч.Ванчинсүрэн (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа)

Шүүгчид:

Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 256 дугаар анги, 113 дугаар тусгай салбар,  
аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар, Цагдаагийн газар,  
Боловсрол, шинжлэх ухааны газар, Соёл, урлагийн газар, Биеийн тамир спортын  
газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын томилогдсон бүрэлдэхүүн.

Аймгийн Засаг даргын 2022 оны  
 05 дугаар сарын 09-ны өдрийн  
 11234 дугаар захирамжийн  
 3 дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ, АЙМГИЙН АВАРГА  
 ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНД  
 ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Хийгдэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Нийт дүн (төг)	Тайлбар
1	Тэмцээний эхний 3 байр эзэлсэн тасагт “Өргөмжлөл” хийлгэх	3ш	55,000	165,000	
2	Тэргүүн байр эзэлсэн тасагт олгох цом хийлгэх	1ш	80,000	80,000	
3	“Дөл” тэмцээний шагнал	I байр II байр III байр	1,000,000 800,000 500,000	2,300,000	
4	Шүүгчдийн өдрийн хоол	15 хүн	8,000	120,000	
5	Шүүгчдийг тээвэрлэх авто машины шатахууны зардал	30 л	2,470	74,100	
6	Эхний 3 байр эзэлсэн сургуулийн захиралд өгөх “Өргөмжлөл”, дурсгалын зураг	3 хүн	30,000	90,000	
7	Тэмцээний оролцогч бүрт олгох “Дурсамж” хэвлүүлэх	300ш	800	240,000	
<b>Нийт дүн</b>				<b>3,069,100</b>	